БАТЛАВ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
..... П.АЛТАНЦЭЦЭГ
2026 оны 09 сарын 30 өдөр

ЭМИЙН ЗӨВЛӨЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЗӨВЛӨЛ, ТЭДГЭЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Эмийн зөвлөл, эмнэлгийн хэрэгслийн зөвлөл (цаашид “зөвлөл” гэх), тэдгээрийн салбар зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг энэхүү удирдамжаар зохицуулна.

1.2.Нээлттэй сонгон шалгаруулалтыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн явуулна.

1.3.Зөвлөл, салбар зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, шударга, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

1.4.Зөвлөл, тэдгээрийн салбар зөвлөлийн гишүүд нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

1.4.1.эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн зөвлөл, төрийн бус байгууллага, мэргэжлийн их, дээд сургуулийн төлөөлөл байх;

1.4.2.мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;

1.4.3. мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай, анагаах ухааны мэргэжлийн эсхүл эрдмийн зэрэгтэй байх;

1.4.4.эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй, хамааралгүй байх;

1.4.5.бүртгэлийн шинжээчээр ажилладаггүй байх;

1.4.6.сахилгын болон ёс зүйн зөрчилгүй байх;

1.4.7.иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;

1.4.8.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх.

Хоёр. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа

2.1.Нээлттэй сонгон шалгаруулалтыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг зохион байгуулна.

2.2.Зөвлөл, салбар зөвлөлийн гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулах тухай зарыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын цахим хуудсанд ажлын 5-аас доошгүй хоног олон нийтэд нээлттэй байршуулна.

2.3.Нээлттэй сонгон шалгаруулах тухай зарыг эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн зөвлөл, төрийн бус байгууллага, мэргэжлийн их, дээд сургуулиудад албан бичиг эсхүл цахим шуудангийн хаягаар хүргүүлж болно.

2.4.Нээлттэй сонгон шалгаруулалтын тухай зарыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хариуцна. Сонгон шалгаруулах тухай зард сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, хүсэлт хүлээн авах эцсийн хугацаа, хүлээн авахаас татгалзах үндэслэл, мэдээлэл ирүүлэх цахим шуудан,шуудан, ажлын байрны хаяг зэрэг мэдээллийг тус тус тусгана.

2.5.Сонгон шалгаруулалтад оролцогчид дараах баримт бичгийг бүрдүүлэн тогтоосон хугацаанд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт цахим шуудан, цаасаар ирүүлнэ:

2.5.1.эмийн зөвлөл, эмнэлгийн хэрэгслийн зөвлөл, салбар зөвлөлийн гишүүнээр ажиллахыг хүссэн өргөдөл;

2.5.2.төлөөлж буй байгууллагын тодорхойлолт (байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагатай хамааралгүй байх);

2.5.3.сахилгын болон ёс зүйн зөрчилгүй талаарх төлөөлж буй байгууллагын тодорхойлолт;

2.5.4.төрийн албан хаагчийн анкет (“Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 521 дүгээр тогтоолоор батлсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын нэгдүгээр хавсралт);

2.5.5.иргэний үнэмлэхийн лавлагаа;

2.5.6.боловсролын дипломын хуулбар;

2.5.7.эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн эсхүл магистр ба түүнээс дээш эрдмийн зэргийн үнэмлэх, дипломын хуулбар;

2.5.8.эрүүл мэндийн бодлого, зохицуулалт, эмнэлзүйн болон эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үйлчлэлийн идэвхийн хүрээнд судалгаа хийсэн бүтээлийн жагсаалт (ирүүлсэн бол үнэлгээнд харгалзана);

2.5.9.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа (E-Mongolia цахим сангаас мэргэжлээрээ ажилласан 10 жил татаж авсан байх);

2.5.10.эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй, хамааралгүй талаарх мэдэгдэл (Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягт) болон сүүлийн 2 жилийн НДШ төлөлтийн лавлагаа (E-Mongolia цахим сангаас татаж авсан байх);

2.5.11.иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт (E-Mongolia цахим сангаас авсан байх);

2.6.Ажлын хэсэг нь шаардлагатай гэж үзвэл баримт бичгийг магадлах зорилгоор нэмэлт баримт бичиг шаардан шалгаж болно.

2.7.Ажлын хэсгийн үнэлгээгээр энэхүү удирдамжийн 1.4-д заасан шаардлагыг хангасан оролцогчдын тоо нь зөвлөл, салбар зөвлөлийн гишүүдийн тоонд хүрээгүй тохиолдолд сонгон шалгаруулалтыг дахин зарлана.

2.8.Ажлын хэсэг нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг ирүүлсэн дарааллын дагуу жагсаалт үүсгэн бүртгэнэ.

2.9.Нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш ирүүлсэн материалыг хүлээн авахгүй.

2.10.Ажлын хэсэг бүртгэл хаагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор үнэлж, сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тухайн өргөдөл гаргагчийн ажлын туршлага, мэргэжлийн онцлог зэргийг харгалзан үзнэ.

2.11.Ажлын хэсэг нээлттэй сонгон шалгаруулалтын шийдвэрийн талаарх мэдэгдлийг оролцогч тус бүр хүргүүлнэ.

2.12.Сонгон шалгаруулалтын дүнг мэдэгдсэнээс хойш сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг ажлын 3 хоногийн дотор ажлын хэсэгт гаргана. Гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэж гомдол гаргагчид хариу хүргүүлнэ.

2.13.Эмийн зөвлөл, эмнэлгийн хэрэгслийн зөвлөлд сонгогдсон гишүүдийн нэрсийг ажлын хэсгийн хурлын шийдвэрийн хамт сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.14.Салбар зөвлөлд сонгогдсон гишүүнийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын тушаалаар томилно.

2.15.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга сонгон шалгаруулалттай холбоотой баримтыг хадгаламжийн нэгж үүсгэж, архивд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.

Гурав. Зөвлөл, салбар зөвлөлд тавигдах шаардлага

3.1.Зөвлөл нь нийт 13-15 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ удирдамжийн 1.4.1-т заасан байгууллагуудаас нэгээс доошгүй төлөөлөл байна.

3.2.Салбар зөвлөл нь нийт 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.3.Зөвлөлийн саналын эрхгүй гишүүн бол салбар зөвлөлд ажиллаж болно.

3.4.Зөвлөлийн гишүүн нь энэ удирдамжийн 1.4-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байхаас гадна дараах чиглэлээр мэргэшсэн байвал зохино.

3.4.1.Эмийн зөвлөлд эм зүйн албаны зохион байгуулалт, эмийн технологи, эмийн шинжилгээ, эмнэлзүйн эм зүй, хүүхэд судлал, дотрын анагаах судлал, уламжлалт анагаах ухаан, хавдар судлал, эмнэлзүйн эм судлал;

3.4.2.Эм судлалын салбар зөвлөлд эмнэлзүйн эм зүй, эмнэлзүйн албаны зохион байгуулалт, эмнэлзүйн эм судлал, эмгэг судлал, дотрын анагаах судлал, мэдрэл судлал, хавдар судлал, халдварт өвчин судлал, хүүхэд судлал, биоанагаах судлал, хор судлал;

3.4.3.Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний салбар зөвлөлд эм зүй, эрүүл мэндийн хоол зүйч, шим тэжээл судлал, биохими, эмнэлзүйн эмгэг судлал, уламжлалт анагаах ухаан, биоанагаах судлаач, нийгмийн эрүүл мэнд, хор судлал;

3.4.4.Эм зүйн салбар зөвлөлд эмийн технологи, эмийн шинжилгээ, эмнэлзүйн эм зүй, биоанагаах судлал, микробиологи;

3.4.5. Биобэлдмэлийн салбар зөвлөлд эм зүй, эмнэлзүй эмгэг судлал, биологи, биотехнологич, тархвар судлал, биохимич, молекул биологич, биоанагаах судлал;

3.4.6.Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлд зүрх судас судлал, мэс заслын нарийн мэргэжил, эх барих, эмэгтэйчүүд судлал, хүүхэд судлал, дүрс оношилгоо судлал, сэргээн засах судлал, нүд судлал, чих, хамар, хоолойн судлал, нүүр, ам судлал, нүд судлал, арьс харшил судлал, эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжил, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ судлал, эмнэлзүйн эмгэг судлал;

3.4.7.Эмнэлгийн хэрэглэгдэхүүний салбар зөвлөлд зүрх судас судлал, мэс заслын нарийн мэргэжил, эх барих, эмэгтэйчүүд судлал, болон хүүхэд судлал, дүрс оношилгоо судлал, сэргээн засах судлал, нүд судлал, чих, хамар, хоолойн судлал, нүүр, ам судлал, нүд судлал, арьс харшил судлал, эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжил, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ судлал;

3.4.8.Лабораторийн оношилгооны хэрэгслийн салбар зөвлөл хүний их эмч, лабораторийн их эмч, микробиологич, биохимич, эмнэлзүйн эмгэг судлал;

3.4.9. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн салбар зөвлөлд зүрх судас судлал, мэс заслын нарийн мэргэжил, эх барих, эмэгтэйчүүд судлал, хүүхэд судлал, дүрс оношилгоо судлал, сэргээн засах судлал, нүд судлал, чих, хамар, хоолойн судлал, нүүр, ам судлал, нүд судлал, арьс харшил судлал, эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжил, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ судлал;

Дөрөв. Хариуцлага

4.1.Нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуулийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн хариуцлага хүлээнэ.

---ООО---